

1990-2003 ОН ХҮРТЭЛХ МОНГОЛ, ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ

*Удо Б. Баркманн**

Өнөөгийн байдлаар, Монгол Улс, БНХАУ-ын улс төрийн харилцаа өндөр түвшинд хүрчээ.

1994 онд БНХАУ-ын Ерөнхий сайд Ли Пэн Монголд дээд хэмжээний айлчлал хийх үеэр гарын үсэг зурсан найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ болон 1999 онд БНХАУ-ын Ерөнхийлөгч Зянь Зэминь Монголд төрийн албан ёсны айлчлал хийсэн томоохон үйл явдлууд нь хоёр улсын хоорондын улс төрийн харилцаанд чухал түлхэц өгчээ. Энэ нь 1961 онд Ю.Цэдэнбал болон Жоу Эньлай нарын байгуулсан найрамдалт харилцаа, харилцан туслалцах гэрээг уламжлан залгамжилсан хэрэг бөгөөд тус гэрээ нь хоёр улсын эдийн засгийн харилцаанд зохих үндэс суурийг тавьсан юм.¹ Ерөнхийлөгч Зянь Зэманий 1999 онд хийсэн төрийн албан ёсны айлчлалаар хоёр улсын хоорондын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа нь “харилцан нөхөх” зарчим дээр суурилна хэмээн тодорхойлсон билээ.

Мөн хоёр орны эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд 1994 онд батлагдсан Монгол Улсын гадаад бодлогын үзээл баримтлал нааштай нөлөө үзүүлсэн юм.² Тус баримт бичигт, Монгол Улс нь гадаад бодлогын хувьд БНХАУ болон ОХУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа хөгжүүлэхийг тэргүүлэх чиг хандлага болгоно гэж заасан билээ. Үүнээс гадна, Монгол Улс нь ОХУ болон БНХАУ-д амьдарч байгаа монгол цөөнхи үндэстнүүдтэй түүх соёлын хэлхээ холбоотойг өмнөх баримт бичигт онцлон тэмдэглэсэн байна.

Монгол Улс болон БНХАУ-ын эдийн засгийн харилцааг олон талаас нь авч үзвэл, нөхцөл бололцоо туйлын өргөн юм. 4.676 километрийн урттай хил хязгаар болон Европ Азийн хооронд гүүр болсон төмөр зам энэ хоёр улсыг холбож байна. Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн улсуудын хувьд тус хоёр орон улс төрийн систем харгалзахгүйгээр зах зээлийн тодорхой чиг шугамыг баримталж байна. БНХАУ-д олон жилийн туршид эдийн засгийн өсөлт явагдаж, үүнтэй уялдаатайгаар түүхий эд, эрчим хүчний хэрэгцээ байнга өсч буй бөгөөд тэрхүү эрэлт хэрэгцээг нь Монгол Улс зэс, алт зэрэг ашигт малтмал,

*Удо Б. Баркманн - МУИС-ийн Монгол Судлалын төвийн зочин профессор, ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн дэргэдэх “Герман Судлал” төвийн гүйцэтгэх захирал

нүүрс, нефт зэрэг эрчим хүчний баялаг материалаараа хангах боломжтой. Нөгөө талаар, БНХАУ тэдгээр ашигт малтмалыг олборлох хангалттай техник технологи болон санхүүгийн чадвартай. БНХАУ хүн амын өсөлтийн хурдаас шалтгаалж, дотооддоо хүнсний хэрэгцээгээ хангахад бэрхшээлтэй болох хандлага гарвал Монгол Улс хойд Хятадын ард түмнийг мах будаагаар хангах бодлогыг боловсруулах үндэслэл бас бий.

Үүнээс гадна, хоёр улсад хамааралтай экологийн асуудал байдаг. Жишээлбэл: Говийн цөлжилт болон усны асуудал. Энэ асуудлыг шийдэхийн тулд улс төр, эдийн засгийн зохицуулалт, хамтын ажиллагаа нэлээн их шаардлагатай юм.

Дээр дурдсан зүйлс нь эдийн засгийн харилцаа хэрхэн харилцан нөхөх боломжтойг харуулж байна.

Миний бодоход, Монгол, Хятадын эдийн засгийн харилцааны өнгөрсөн 10 жилийн хөгжлийг гурван үе шатанд хувааж болно. Монгол, Хятадын хөгжлийн замын өвөрмөц онцлог аль ч үе шатанд харилцан адилгүй нөлөөтэй байлаа. Монголын улс төрийн систем өөрчлөгдсөний дүнд зах зээлийн эдийн засагт шилжсэн бөгөөд олон талын гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр эдийн засгийн гүнзгий хямралд орсон билээ. Олон аж ахуйн нэгжүүд дампуурч, ажилгүйдэл урьд байгаагүй хэмжээгээр нэмэгдэж, нийгмийн бүтцэд янз бүрийн эргэлт буцалтгүй өөрчлөлт гарчээ. Жишээлбэл: Хөдөө орон нутгийн хувьд өмнө суурьшмал байсан хүмүүсийн дийлэнх хэсэг нүүдлийн мал аж ахуй эрхэлж, аж үйлдвэрийн салбарт ажиллаж байсан мэргэжлийн ажилчид жижиг худалдаа үйлчилгээний салбарт ажиллах болжээ.

Энэ цаг үед БНХАУ социалист системээ хадгалж, эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлсний үндсэн дээр зах зээлийн аж ахуйн зохих бүтцэд шат шатаар шилжиж эхэлсэн юм.

1990-1994 он хүртэлх Монгол, Хятадын эдийн засгийн харилцааны нэгдүгээр шатанд хоёр орон улс төрийн харилцаагаа сэргээж, хэвийн болгосон нь эдийн засгийн харилцааг хөгжүүлэх нөхцөл боломж бүрджээ.

Хоёрдугаар үе шат 1994-1999 оныг хүртэлх хугацааг хамарч байна. Найрсаг харилцаа хамтын ажиллагааны тухай гэрээнд гарын үсэг зурсан явдал энэ үе шатын эхлэл болжээ. Тус гэрээ нь эдийн засгийн харилцаатай холбогдох бусад гэрээ хэлэлцээрийг байгуулах хууль зүйн үндэс, нөхцөл болж байв. Энэ үе шатанд хоёр улсын эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд чиглэгдсэн логистикийн дараах үндэслэл бий болжээ. Үүнд:

Нэгдүгээрт: Хоёр улсын хил хязгаарт тээврийн машин болон зорчигчдын хилийн боомтын систем бий болгох;

Хоёрдугаарт: Хоёр улсын хилийн ойр орчмын бүс нутгийн шууд харилцаа байгуулах; Монгол, Хятад, Орос, Хойд Солонгосын хоорондын зорчигч, ачааны тээврийг зохицуулах, үүнтэй холбогдуулан төмөр замыг сайжруулах, Замын-Үүд-Эрээний хилийн боомтын хүчин чадал, нөхцөл бололцоог нэмэгдүүлэх (Замын-Үүдээс Хятадын хил хүртэл 4.5 км урттай засмал зам байгуулсан.)

Дэд бүтцийн дээрх арга хэмжээнүүд 1993-1995 он хүртэлх хугацаанд Монголын талын экспортыг нэмэгдүүлэхэд нааштай нөлөө үзүүлэв. Экспортын хэмжээ 3.4 сая доллараас (1993 он) 100 сая ам.доллар (1996 он) хүрсэн юм. Хятадаас авсан импорт 1995 он хүртэл 60 сая ам.долларын хэмжээнд хүрчээ. Монгол Улс, Хятадад мал аж ахуйн түүхий эд экспортолж, харин монгол наймаачид дотоод зах зээлийнхээ хэрэгцээг хангахын тулд өргөн хэрэгцээний маш хямд барааг импортолж байв.³ Тийм учраас, тухайн үеийн экспорт, импортын худалдаанд янз бүрийн асуудал тулгарч байсан юм.

1993 он хүртэл Монгол Улсын Засгийн газар өөрийн хяналтан дор гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулж байсан бол түүнээс хойш зөвхөн эдийн засгийн нэгжүүд болон хувь хүний хооронд шийдэх асуудал болсон байна. Үүний улмаас, Монгол Улсын засгийн газар гадаад худалдааны зохицуулалтын боломжоо алдахад хүрчээ. Практик амьдралд Монголд хөнгөн аж үйлдвэрүүд өөрийн үйлдвэрлэлээ түүхий эдээр хангах боломжгүй болжээ. Монгол, Хятадын худалдааны хэмжээ 1999 он хүртэл 285.8 сая долларт хүрсэн байна. Энэ хугацаанд экспортын хамгийн чухал бараа нь ямааны боловсруулаагүй ноолуур байсан нь зохих сөрөг нөлөөг үзүүлжээ. Жишээлбэл: Ямаан сүргийн тоо толгойг эрс нэмэгдүүлснээр (сүүлийн 10-аад жилд 4.5-аас 11 сая хүрчээ) Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь аймагт бэлчээрийн даац хэтэрсэн байна.

Үүнээс гадна, Монгол Улс ямааны ноолуурыг дотооддоо боловсруулбал зах зээлд илүү ашгийг олох боломжтой. Жишээлбэл: 1999 онд Улаанбаатарын зах дээр ямааны боловсруулаагүй нэг килограмм ноолуурын үнэ 246 юань байсан бол Хятадын зах зээлд 600-700 юань байв. Нөгөө талаар, Монголоос ноолуур нийлүүлж байсан Хятадын пүүсүүд ноолуур авахын тулд өөрийн улсын банкнаас хангалттай зээлийг авах бололцоотой байв.

Хоёр улсын эдийн засгийн харилцааны хоёрдугаар үе шатанд, БНХАУ Монгол Улсын хамгийн чухал түнш болжээ. Зөвхөн 1998 оны байдлыг авч үзвэл, БНХАУ-аас Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт нь гадаадын нийт хөрөнгө оруулалтын 21 хувийг эзэлж байв. Энэ үед гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжгийн 31 хувь нь Монгол-Хятадын хамтарсан аж ахуйн нэгжүүд байлаа. БНХАУ-аас Монгол Улсад жижиг үйлдвэр байгуулах, өргөн хэрэглээний барааг илүү сайн хангах болон геологи, уул уурхайн салбарт янз бүрийн жижиг төслийг хэрэгжүүлэх зорилгоор 1991 онд 50 сая юань, 1992 онд 30 сая юань, 1994 онд 50 сая юаний зээл олгожээ.

Ерөнхийлөгч Зянь Зэманий 1999 онд хийсэн төрийн айлчлал Монгол-Хятадын эдийн засгийн харилцааны гуравдугаар шатны эхлэл болсон юм. Зянь Зэманий гаргасан “харилцан нөхөх” хэмээх зарчим нь хамтын ажиллагааны нэн шинэ алхам болжээ. “Харилцан нөхөх” гэсэн нь юу гэсэн үг вэ?

Нэгдүгээрт: Хоёр улсын хооронд стратегийн чиглэлтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх;

Хоёрдугаарт: Монгол Улс болон БНХАУ дахь эдийн засгийн харилцааны үндсэн ашиг сонирхлыг харгалзах болон зохицуулах.

Энэ үүднээс үзвэл, “харилцан нөхөх” зарчим нь хоёр улсын хоорондын дэд бүтцийн хэлхээ холбоог хөгжүүлэн бэхжүүлэх болон аюулгүй бодлогын зохистой хүрээ тогтоохыг шаардаж байна. Хамгийн сайн жишээ бол, Оросын Ковыхтинскээс Хятад руу хийн хоолой тавих төслийн тухай санал шүүмжлэл юм. Тус хийн хоолойн төслийн хэрэгжүүлэлтийн хамгийн бага өртөгтэй зам бол Монголын төмөр замын дагуух чиглэл юм. Хятад улс аюулгүй байдлын боллогын учир шалтгаанаар одоо болтол энэ боломжоос түдгэлзсэн болов уу.

Гуравдугаар үе шатанд БНХАУ-ын эдийн засгийн нөлөө оролцоо Монгол Улсад нэмэгдсэн юм. 2002 оны мэдээгээр авч үзвэл, БНХАУ Монгол улсад 1991 оноос эхлэн 215 сая юаний буцалтгүй тусламж, 130 сая юаний хүүгүй зээл болон 200 сая юаний бага хүүтэй зээл олгосон байна. *Үүнээс үзэхэд, БНХАУ, Монгол улсын хувьд хандивлагч улсын үүрэг гүйцэтгэж байна.* Хоёр улсын хоорондын худалдааны хэмжээ 2003 онд 362 сая долларт хүрчээ. Энэхүү эдийн засгийн харилцааны өсөлтөд Монгол-Хятадын хамтарсан үйлдвэр болон Хятадын пүүсүүд зохих хувь нэмрээ оруулсан гэж хэлж болно. 2001 онд Монгол Улсад Монгол-Хятадын хамтарсан үйлдвэр, Хятадын пүүс, компани 553 байсан бөгөөд тэдгээр нь 103.75 сая долларын хөрөнгө

оруулсан бол 2003 онд 850 аж ахуйн нэгж нийтдээ 280 сая долларын хөрөнгө оруулжээ. 2003 оны 8 дугаар сарын мээдээгээр Монгол Улсад Хятадын 1059 пүүс 296 сая америк долларын хөрөнгө оруулалт хийжээ.⁴ Энэ нь БНХАУ өнөөдөр Монголд хамгийн том хөрөнгө оруулагч болсныг харуулж байна.

Монгол-Хятадын хамтарсан үйлдвэр, аж ахуйн нэгжүүд худалдаа, оёдол, нэхмэл болон хөдөө аж ахуйн салбарт гол төлөв үйл ажиллагаа явуулж байна. БНХАУ-ын хамгийн их хөрөнгө (200 сая юань) оруулсан төсөл нь Сүхбаатар аймагт байгаа Төмөртийн цайрын орд ажээ. Энэ төсөл нь БНХАУ-д улс төрийн чухал ач холбогдолтой юм. Тодруулан хэлбэл, Эрдэнэтийн зэс молибдений үйлдвэр ОХУ, Монгол Улсын харилцаанд хамгийн чухал ач холбогдолтой байгаагийн адил Төмөртийн цайрын ордын үйлдвэрийг БНХАУ, Монгол Улсын хоорондын эдийн засгийн харилцааны үлгэр жишээч нэгж болгохыг зорьж байна.

Сүүлийн үед БНХАУ, Монгол Улсын хооронд геологи, уул уурхайн салбарт янз бүрийн шинэ төслүүд яригдаж байна. Хятадын тал Өмнөговь аймагт буй Оюунтолгойн зэс алтны орд болон Өмнөговь аймгийн Гурвантэс суманд нээсэн чулуун нүүрсний ордыг их сонирхох болжээ. Тус ордыг олборлох, ашиглахын тулд Өмнөговь аймгийн хилийн ойрхон газрыг БНХАУ-тай дэд бүтцийн хувьд холбох хэрэгтэй. Энэ тухайд БНХАУ зохих бэлтгэлийг хангасан бөгөөд Монгол Улсын Шивээхүрэн хэмээх хилийн боомттой хиллэдэг Чэхэ боомт хүрэх замыг шинээр тавьжээ. Мөн БНХАУ-ын талаас Гурвантэс суманд хүрэх 28 километр нарийн төмөр замыг тавьж байна.

Дээр дурдсаны нэгэн адил, Монголын зүүн хязгаарт байгаа цайр, нефтийн ордыг олборлох, ашиглах тухайд ч тус бүс нутгийг Хятадын дэд бүтэцтэй холбох бодит шаардлага тулгарч байна. Үүнтэй уялдан Чойбалсан болон Рашаантын хооронд төмөр зам тавих нь зөвхөн цаг хугацааны асуудал байх аа. Хоёр улсын хил залгаа нутгийн дэд бүтцийг холбох нь тухайн бүс нутгийн эдийн засгийн хөгжилд зохих түлхэц өгөх болно.

Монгол Улс, БНХАУ-ын хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаа шинэ шатанд орж байгаатай холбогдуулан гадаад бодлогын зарим чиг баримтлалыг аюулгүй байдлын бодлогын үүднээс шинээр боловсруулах шаардлагатай болов уу. Тэгэхдээ жишээлбэл өнөө үеийн түр зуурын шинжтэй зарим бодлогын оронд Монгол Улсын болон хоёр хөрш орны ард түмний эрхэм ашиг сонирхлыг тэргүүн зэрэгт тавих нь

чухал байж магадгүй. Дэлхий дахинд болж буй өнөөгийн үйл явдал Нэгдсэн Үндэстний Байгууллагын тунхаг бичигт заасан энх тайванч хамтын ажиллагаанаас илүү сайн альтернатив сонголт байхгүй болохыг хүн бүхэнд харуулж байна.

Энэ бүхнийг дүгнэн хэлэхэд, Монгол-Хятадын эдийн засгийн харилцаа шинэ шатанд гарч, цаашид ч улам бүр өсөн хөгжих ирээдүйтэй бөгөөд харин зарим том хэмжээний хамтарсан төсөлд (жишээлбэл Оюунтолгойн зэсийн орд нээхэд 2 тэрбум америк долларын хөрөнгө оруулалт шаардлагатай болох) Зүүн хойд Азийн бүс нутгийн гуравдагч улс орны оролцоо байвал, тус бүс нутгийн интеграцичлалд тус дөхөмтэй болох биз ээ.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. U.B.Barkmann, Die Beziehungen zwischen der Mongolei und der Volksrepublik China (1952-1996), Versuch einer Anamnese, = Mitteilungen des Institutes für Asienkunde 338, Hamburg 2001, 190 дүгээр тал
2. Монгол Улсын Гадаад Бодлогын Үзэл баримтлал, Ардын Эрх, 1994 оны 7 дугаар сарын 27-ны өдөр.
3. U.B.Barkmann, Zu Stand und Bedingungen der mongolisch-chinesischen Wirtschaftsbeziehungen der letzten Jahre, Newsletter Frauen und China, Nr. 8, März 1995, Hrsg. Ostasiatisches Seminar der Freien Universität Berlin, Sinologie, 44-50 дугаар тал
4. Хуан Жакуй, Далай ламын тухай бид өөр ойлголттой, Зууны мэдээ, 2003 оны 10 дугаар сарын 9-ны өдөр.